

## АМЬЖИРГААГ ДЭМЖИХ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 27.1-т заасан үүрэг бүхий нийгмийн халамжийн үйлчилгээний хэрэгжилтэд хяналт тавих олон нийтийн оролцоот орон тооны бус зөвлөл мөн.

1.2. Зөвлөл нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-12.1.5-д заасан тэтгэвэр, 13 дугаар зүйлийн 13.2, 13.5.1-13.5.4, 13.5.6-13.5.7-д заасан тэтгэмж, 18 дугаар зүйлийн 18.1-д заасан үйлчилгээ, Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-д заасан мөнгөн тусламж, Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан тэтгэмжид хамрагдах хүсэлт гаргасан өрх, иргэний баримт бичиг, амьдралын нөхцөлийг нь судлан үзэж, тэдгээрийг холбогдох нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах эсэхийг хэлэлцэн шийдвэрлэнэ.

1.3. Сум, хороонд Нийгмийн халамжийн тухай хуулийн 27.2, 27.3 дахь хэсэгт заасны дагуу Зөвлөлийг байгуулан ажиллуулна. 2000-аас дээш хүн амтай баг, тосгонд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр Зөвлөл ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр батална.

1.4. Зөвлөл нь нийгмийн халамжийн хууль тогтоомж болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.5. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэхүү дүрмийн 4.2.5-д заасан тайланг үндэслэн Зөвлөлийн гишүүнд Нийгмийн халамжийн тухай хуулийн 27.10-т заасны дагуу нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан хэмжээнд багтаан улиралд нэг удаа урамшуулал олгоно.

1.6. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь хууль тогтоомжийн хүрээнд шударга, шуурхай, ил тод, санаачлагатай ажиллаж, зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой сайн туршлагыг түгээж, нийгмийн халамжийн үйл ажиллагааг иргэдэд чирэгдэлгүй хүргэхэд хувь нэмэр оруулж буй Зөвлөлийг хагас, бүтэн жилээр шалгаруулан шагнаж урамшуулж болно.

## **Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах**

2.1. Сум, хорооны Засаг дарга нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 27.2 дахь хэсэгт заасны дагуу Зөвлөлийн бүрэлдэхүүнд нэр дэвшүүлэхдээ тус хуулийн 27.3, 27.4-т зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

2.1.1. Зөвлөлийн бүрэлдэхүүнд нэр дэвшигчид нь нэг гэр бүлийн болон садан төрлийн холбоотой байж болохгүй;

2.1.2. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг өрхийн иргэн байж болохгүй;

2.1.3. Төрийн байгууллагын төлөөлөлд эмнэлэг, сургуулийн нийгмийн ажилтан зэрэг иргэдийн амьдралын нөхцлийг сайн мэдэх мэргэжлийн хүмүүсийг санал болгох;

2.1.4. Иргэний төлөөлөлд тухайн сум, хороонд 5-аас доошгүй жил оршин сууж байгаа, нийгмийн идэвхтэй, шударга, орон нутагтаа нэр хүнд бүхий иргэнийг санал болгох;

2.1.5. Төрийн бус байгууллагын төлөөлөлд тухайн сум, хорооны нутаг дэвсгэрт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын төлөөлөгчдийг санал болгох;

2.2. Зөвлөлийн гишүүд санал хураах замаар Зөвлөлийн даргыг сонгоно. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь сум, хороо /баг, тосгон/-ны халамжийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан байна.

2.3. Зөвлөлийн гишүүн нас барсан, эсвэл хүндэтгэн үзэх шалтгааны улмаас цаашид Зөвлөлийн үйл ажиллагаанд оролцох боломжгүй болсноо бичгээр илэрхийлсэн тохиолдолд Нийгмийн халамжийн тухай хуулийн 27.2, энэхүү дүрмийн 1.3-т заасны дагуу түүний оронд ажиллах гишүүнийг 30 хоногт нөхөн томилно.

2.4. Зөвлөлийн гишүүн холбогдох хууль тогтоомж, энэхүү дүрмийг удаа дараа зөрчсөн буюу хүлээсэн үүргээ биелүүлээгүй, Зөвлөлийн хурлыг шалтгаангүйгээр удаа дараа тасалсан, Зөвлөлийн гишүүний эрхээ буруугаар ашигласан зэрэг тохиолдолд Зөвлөлийн дарга, эсвэл гишүүдийн саналыг үндэслэн сум, хорооны Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тухайн гишүүнийг өөрчлөх асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ.

## **Гурав. Зөвлөлийн хурал**

3.1. Зөвлөл нь сард хоёроос доошгүй удаа хуралдана. Зөвлөлийн хурлыг Зөвлөлийн дарга удирдах бөгөөд шаардлагатай тохиолдолд түүний эзгүйд зөвлөлийн гишүүдийн аль нэг нь Зөвлөлийн даргын шийдвэрээр түүнийг орлоно.

3.2. Зөвлөл хуралдах хуваариа хурлаараа хэлэлцэн шийдвэрлэж, тухайн сум, хорооны иргэд, олон нийтэд ил тод байршуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд сум,

хорооны нийгмийн ажилтны санал болгосноор Зөвлөлийн дарга хурлыг хугацаанаас нь өмнө зарлан хуралдуулж болно.

3.3. Зөвлөлийн хуралд нийт гишүүдийн олонх нь оролцсоноор тухайн хурлыг хүчинтэйд тооцно. Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлыг олонхын саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд Зөвлөлийн даргын саналыг харгалзана. Хурлын тэмдэглэлийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтлөх бөгөөд уг тэмдэглэлд Зөвлөлийн дарга болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

3.4. Зөвлөлийн шийдвэр нь хурлын тэмдэглэлд тусгагдах бөгөөд шийдвэрийн хэсгийг хуралдаанд оролцсон бүх гишүүдийн гарын үсгээр тухайн сум, хөрөөны Засаг даргын тамгаар баталгаажуулна. Зөвлөл нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 27.7-д заасны дагуу хурлын шийдвэрийг нийтэд нээлттэй, ил тод байлгана.

3.5. Зөвлөл нь төрийн мэдээллийн санд байгаа иргэний мэдээлэл, цахим баримт материалыг цахимаар шалган зөвлөлөөс гарсан шийдвэрийг мэдээллийн сан /ehalamj.mn/-д оруулна.

3.6. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хурлын тэмдэглэлийг улиралд нэг удаа аймаг, дүүргийн халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүргүүлнэ.

3.7. Зөвлөлийн үйл ажиллагааг Зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцан гүйцэтгэх бөгөөд хуралд оруулах асуудлын бүрдлийг хариуцан хянаж бэлтгэнэ.

3.8. Зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүд нь энэхүү дүрмийн 1.2-т заасан өрх, иргэний амьдралын нөхцлийг нь судлан үзэж, хууль тогтоомжид заасан хугацаанд хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ.

#### **Дөрөв. Зөвлөлийн эрх, үүрэг**

4.1 Зөвлөл нь доор дурдсан эрх эдэлнэ:

4.1.1. Зөвлөл нь энэхүү дүрмийн 1.2-т заасан өрх, иргэний амьдралын нөхцөлийг нь судлах, баримт бичгийг нь магадлах зорилгоор ахуй байдалтай нь танилцах, өөрсдөөс нь болон холбогдох бусад байгууллага, иргэнээс шаардлагатай лавлагаа, тодруулга мэдээлэл авах, шалгаж нягтлах, хууль тогтоомжид заасан нөхцөл болзлыг хангахгүй болсон иргэдийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээг зогсоох талаар санал гаргах;

4.1.2. Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар санал боловсруулах, холбогдох асуудлыг төрийн байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

4.1.3. Зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдох зайлшгүй зардлыг төлөвлөн саналыг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлэх;

4.1.4. Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.3-т заасны дагуу тухайн сум, хорооны хэмжээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд шаардагдах хөрөнгийн талаар санал гаргах;

4.1.5. Эрх хэмжээнийхээ хүрээнд тухайн орон нутагт оршин суугаа Нийгмийн халамжийн тухай хуулийн 4.1 дэх хэсэгт заасан иргэнийг нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамруулахаар санал гаргах, хуулийн дагуу холбогдох байгууллагад уламжлах;

4.1.6. Хууль тогтоомжид заасан бусад эрх.

4.2. Зөвлөл нь доор дурдсан үүрэг хүлээнэ.

4.2.1. Энэхүү дүрмийн 1.2-т заасан өрх, иргэний баримт бичиг, амьдралын нөхцөлийг судлан үзэж, хууль тогтоомжид заасан хугацаанд хэлэлцэж шийдвэрлэх, холбогдох байгууллагад шийдвэрийг хүргүүлэх;

4.2.2. Зөвлөлийн шийдвэрийн дагуу нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээнд хамрагдаж буй өрх, иргэний амьдралын нөхцөл байдалд гарч буй өөрчлөлтөд хяналт тавьж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох байгууллагад уламжлах;

4.2.3. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж буй өрх, иргэдийг тухайн орон нутгийн хэмжээнд хэрэгжиж байгаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах, орлого нэмэгдүүлэх чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдэд хамруулж, амьжиргаагаа дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх талаар санаачлага гаргах;

4.2.4. Үйл ажиллагаагаа суманд иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд, хороонд иргэдийн Нийтийн Хуралд жил тутам, сум, хорооны Засаг дарга болон аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад улирал тутам тайлагнах. Тайланд гишүүдийн хурлын ирц, оролцоо, энэхүү дүрмийн 1.2-т заасан өрх, иргэний амьдралын нөхцөлийг судлах ажилд биечлэн оролцсон байдал зэргийг тодорхой тусгах;

4.2.5. Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасан тэтгэмжид хамрагдах иргэний асуудлаар тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д заасан иргэнийг удаа дараа буруу тогтоосон Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журмын 2.8-д заасан байгууллага, эрх бүхий албан тушаалтны талаар Нийгмийн халамжийн байгууллагад мэдэгдэх;

#### 4.2.6. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

##### **Тав. Бусад зүйл**

5.1. Энэхүү дүрмийн 1.2-т заасан өрх, иргэн нь Зөвлөлийн шийдвэртэй санал нийлэхгүй тохиолдолд зөвлөлд гомдол гаргаж болно. Зөвлөл гомдлыг 14 хоногийн дотор дахин хянан үзэж шийдвэрлэнэ.

5.2. Зөвлөлөөс дахин хянаж гаргасан шийдвэрийг тухайн өрх, иргэн хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд харьяа аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон төв байгууллага, зохих шатны шүүхээр маргаанаа хянан шийдвэрлүүлж болно.

5.3. Энэхүү дүрмийн 1.2-т заасан өрх, иргэний амьдралын нөхцөлийн талаар зориудаар үндэслэлгүй шийдвэр гаргах, эсхүл хувийн зорилгод ашиглах зэргээр хууль тогтоомж зөрчсөн Зөвлөлийн дарга, нийгмийн ажилтан, зөвлөлийн гишүүдэд Нийгмийн халамжийн тухай хуулийн 31 дүгээр зүйл болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.4. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь Зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөлийн гишүүдийг сургах, үйл ажиллагаатай нь танилцах ажлыг жил бүрийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлнэ.

5.5. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны талаар улсын хэмжээний бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэн шинэчилж ажиллана.